МОНГОЛ УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗАР

**САНХҮҮ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ГАЗРЫН**
**ТӨСӨЛ, ХӨТӨЛБӨРИЙН ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ**
**Д.БАЯРМААГИЙН 2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН**

/БАЙГУУЛЛАГЫН НЭР: ХОТ БАЙГУУЛАЛТ, БАРИЛГА, ОРОН СУУЦЖУУЛАЛТЫН ЯАМ/

*ХЯНАСАН:*

САНХҮҮ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГА .......................... /Ц.АРИУНСАНАА/

*ТАЙЛАГНАСАН:*

ТӨСӨЛ, ХӨТӨЛБӨРИЙН ХЭЛТСИЙН
ШИНЖЭЭЧ .......................... /Д.БАЯРМАА/

Тэмдэг ..........2024.12.20.

(огноо)

*Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын*
*даргын 2023 оны 98 дугаар тушаалын*
*6 дугаар хавсралт*

Санхүү, хөрөнгө оруулалтын газрын Төсөл хөтөлбөрийн хэлтсийн шинжээч Даваагийн Баярмаагийн

# 2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

2024.12.12

| **№** | **Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ** | **Шалгуур үзүүлэлт** | **Суурь түвшин** | **Хүрэх түвшин** | **Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/** | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| **Стратеги төлөвлөгөөний зорилго 5.** Санхүү, хөрөнгө оруулалт, үйлдвэрлэлийн үр ашиг, хүртээмжийг дээшлүүлэх, төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэх, салбарын болон гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэх, гадаад, дотоодын хөрөнгө оруулалтыг дэмжих: | | | | | | | |
| **Зорилт 1:**Хөрөнгө оруулалтын бодлогын хэрэгжилтийг хангаж төсвийн ерөнхийлөн захирагчийн урсгал болон хөрөнгө оруулалтын төсвийг төлөвлөх, хуваарилах, хяналт тавих | | | | | | | |
| 1 | **Арга хэмжээ 1.1:** Гадаад зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй төслүүдээс гадаад хөрөнгө оруулалтын талаар төсвийн хязгаарт санал авч, 2025 оны төсвийн төсөл, 2026-2027 оны төсвийн төсөөллийг нэгтгэлд холбогдох тооцоо, судалгаа, тайлбар танилцуулгын хамт хүргүүлэх. | **ШҮ1:хугацаа/** 2025 оны төсвийн төсөл, 2026-2027 оны төсвийн төсөл/<br><br>**ШҮ2:Байгууллагын тоо;** | Төслийн тоо-11 | Төслийн тоо-7 | Гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа төслүүдийн хүрээнд 2024 онд гадаад зээл, буцалтгүй тусламжид 350,321.1 сая төгрөг, Улсын төсөв /Монголын талын хөрөнгө/-т нийт 45,947.8 сая төгрөг тус тус батлагдсан байна.<br><br>Барилга, хот байгуулалтын сайдын 2024 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн 56 дугаар тушаалаар дараах төслүүдийн Монголын талын хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалт батлуулсан. Үүнд:<br>1. “БНХАУ-ын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр хэрэгжиж буй “Төв цэвэрлэх байгууламжийг шинээр барих төсөл”-ийн Монголын талын хөрөнгө /Улаанбаатар/”;<br>2. “БНХАУ-ын буцалтгүй тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж буй “Ногоон нуур 1008 айлын орон сууц барих төсөл”-ийн Монголын талын хөрөнгө /Улаанбаатар/“;<br>Гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа 7 төслийн хүрээнд | 6 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | гадаад зээлээс 306,920.6 сая төгрөг, Улсын төсөв /Монголын талын хөрөнгө/-т 34,437.6 сая төгрөгийн саналыг холбогдох төслийн танилцуулгын хамт 2025 оны төсвийн хязгаарт хүргүүлсэн. | | |
| | **Зорилт 2:** Улсын төсөв, гадаадын зээл, тусламж, бусад эх үүсвэрээр хэрэгжих төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг нэгтгэн зохицуулах: | | | | | | |
| 2 | **Арга хэмжээ 2.1:** Гадаад зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж буй төслүүдийн барилга угсралтын үе шатны ажлын гүйцэтгэл болон Төсөл хэрэгжүүлэх нэгжийн үйл ажиллагааны зардлын төсвийг хянан, баталгаажуулах, хэрэгжилтэд хяналт тавих. | **ШҮ1:**Хэрэгжилтийн хувь;<br>**ШҮ2:**Төслийн тоо;<br>**ШҮ3:**Батлагдсан ТХН-ийн төсөв: | 2023 онд хэрэгжүүлсэн төслийн тоо- 11;<br>Хөрөнгө оруулалтын хэрэгжилтийн хувь- 65%.<br>Батлагдсан ТХН-ийн төсөв-24 удаа;<br>ТХН-ийн урсгал зардлын гүйцэтгэлийн хувь- 90% | 2024 онд хэрэгжүүлэх төслийн тоо-7, хөрөнгө оруулалтын хэрэгжилтийн хувь 90%.<br>Батлагдсан ТХН-ийн төсөв-17 удаа;<br>ТХН-ийн урсгал зардлын гүйцэтгэлийн хувь-90% | Гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа дараах 7 төслийн хүрээнд 2024 оны хөрөнгө оруулалтад 615,206,85 сая төгрөг батлагдсан бөгөөд 592,142.48 сая төгрөгийн санхүүжилтийг хянаж, баталгаажуулан шийдвэрлүүлсэн. Хөрөнгө оруулалтын гүйцэтгэл 96% байна. Үүнд:<br>1. БНСУ-ын зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй “Солонго 1 орон сууцны хороолол барих төсөл”- 169,362.07 сая төгрөг;<br>2. БНСУ-ын зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй “Солонго 2 орон сууцны хороолол барих төсөл”-138,119.14 сая төгрөг;<br>3. АХБ-ны зээлээр хэрэгжиж буй “Дархан хотын бохир усны менежментийн МОН-3244/3245 төсөл-3,292.56 сая төгрөг;<br>4. БНАУ-ын Дархан хотын цэвэр усны шугам сүлжээг өргөтгөх, шинэчлэх, ухаалаг тоолуур нэвтрүүлэх төсөл-14,964.39 сая төгрөг ;<br>5. БНХАУ-ын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй “Улаанбаатар хотын төв цэвэрлэх байгууламжийг шинээр барих төсөл”-220,310.22 сая төгрөг;<br>6. БНПУ-ын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй “Аймгуудын бохир ус цэвэрлэх байгууламжийг өргөтгөн шинэчлэх, шинээр барих төсөл”- 18,650.0 сая төгрөг;<br>7. БНХАУ-ын буцалтгүй тусламжаар хэрэгжиж буй “Ногоон нуур | 1-12 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | 1008 айлын орон сууц төсөл"-30,331.96 сая төгрөг.<br>Тус яамны харьяа нийт 5 Төсөл хэрэгжүүлэх нэгжийн хүрээнд 2024 оны үйл ажиллагааны урсгал зардлыг 4 улирлаар 21 удаагийн төсвийг хянан баталгаажуулсан ба 4,728.48 сая төгрөг төсөвлөгдсөн. Үүнээс гүйцэтгэлээр 4,250.45 сая төгрөг зарцуулж, 478.03 сая төгрөгийн хэмнэлттэй байна. Урсгал гүйцэтгэл-90%<br><br>- ХЗДХЯ-руу "Ардааган" ХХК-ийн нэмэлт санхүүжилтийн асуудлаар Чингэлтэй дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 182/ШШ2019/01057 дугаартай шийдвэрийн дагуух нөхөн төлбөрийн асуудлаар албан бичиг хүргүүлсэн. | | |
| 3 | **Арга хэмжээ 2.2:** Салбарын хэмжээнд гадаад зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжсэн төслүүдийн хүрээнд бий болсон хөрөнгийн өмчлөлийн судалгааг гаргаж, хөрөнгийн өмчлөлийг шийдвэрлүүлэх саналыг ТӨБЗГ-т хүргүүлэх, холбогдох байгууллагуудад хүргүүлэн нягтлан бодох бүртгэлд тусгуулах. | **ШҮ1:**Төслүүдийн хөрөнгийн өмчлөлийн судалгаа;<br>**ШҮ2:**ТӨБЗГ-т хүргүүлсэн хөрөнгийн өмчлөлийн санал;<br>**ШҮ3:**ТӨБЗГ-ын тогтоолын хэрэгжилт. | 2023 оны хөрөнгийн өмчлөлийн судалгаа;<br><br>Гадаад зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж дууссан төслийн тоо-4;<br><br>Төслийн хүрээнд бий болсон нийт 219,276.04 сая төгрөгийн хөрөнгийн өмчлөлийг шийдвэрлүүлсэн. Хэрэгжилт-94% | 2024 оны хөрөнгийн өмчлөлийн судалгаа;<br><br>Дууссан төслийн тоо-4;<br><br>ТӨБЗГ-т хүргүүлсэн хөрөнгийн өмчлөлийн санал-4. | Барилга, хот байгуулалтын салбарт гадаад зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжсэн 10 төслийн хөрөнгийн өмчлөлийн судалгааг гарган удирдлагад цахимаар хүргүүлсэн.<br><br>Энэ онд 5 төсөл бүрэн дууссан бөгөөд дараах 4 төслийн хүрээнд нийт 125.04 тэрбум төгрөгийн хөрөнгийн өмчлөлийн шийдвэрийг гаргуулах саналыг ТӨБЗГ-т албан бичгээр хүргүүлсэн. Үүнд:<br><br>Дэд бүтцийн хөгжил-СХД;<br><br>Дэд бүтцийн хөгжил БЗД, Дархан, Сэлэнгэ;<br><br>"Зүүн өмнөд говийн хот байгуулалт, хилийн ойролцоо суурин газруудын хөгжлийн МОН-3388 төсөл"; | 1-12 | 95 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | “Зүүн өмнөд говийн хот байгуулалт, хилийн ойролцоо суурин газруудын хөгжлийн МОН-3713 төсөл”.<br><br>Азийн хөгжлийн банкны зээлийн хөрөнгөөр хэрэгжсэн “Зүүн өмнөд говийн хот байгуулалт, хилийн ойролцоо суурин газруудын хөгжлийн МОН-3388 төсөл”-ийн хөрөнгийн өмчлөлийн шийдвэр ТӨБЗГ-ын 2023 оны 284 дүгээр тогтоолоор “Зүүн өмнөд говийн хот байгуулалт, хилийн ойролцоо суурин газруудын хөгжлийн МОН-3713 төсөл”-ийн хөрөнгийн өмчлөлийн шийдвэр ТӨБЗГ-ын 2024 оны 231 дүгээр тогтоолоор тус тус баталгаажсан.<br><br>Энэ дагуу ашиглагч байгууллагад шилжүүлэх талаар 2024 оны 3/1678, 3/1679, 3/1680, 3/1681, 3/1683 тоотоор холбогдох 5 аймгийн Орон нутгийн өмчийн газарт ашиглагч байгууллагын балансад бүртгүүлэх хүсэлтийг хүргүүлсэн.<br><br>“Зүүн өмнөд говийн хот байгуулалт, хилийн ойролцоо суурин газруудын хөгжлийн МОН-3388 төсөл”-ийн хүрээнд 45.14 тэрбум төгрөгийн хөрөнгийг холбогдох 4 аймгууд балансад бүртгэсэн байна. Дорноговь аймгийн хувьд 11.0 тэрбум төгрөгийн хөрөнгийн өмчийн шийдвэрийг гаргуулахаар ИТХ-ын ээлжит хурал хүлээгдэж байна.<br><br>“Зүүн өмнөд говийн хот байгуулалт, хилийн ойролцоо суурин газруудын хөгжлийн МОН-3713 төсөл”-ийн хүрээнд 33.5 тэрбум төгрөгийн хөрөнгийн бүртгэл хийгдсэн бөгөөд 11.4 | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | тэрбум төгрөгийн хөрөнгийн өмчийн шийдвэрийг гаргуулахаар тус яамнаас 2024 оны 11 дүгээр сарын 05-ны өдрийн 09/1213 тоот албан бичгийг Сүхбаатар аймгийн ОНӨГ-т хүргүүлсэн. ИТХ-ын ээлжит хурал хүлээгдэж байна.<br><br>Бүгд Найрамдах Австри Улсын зээлийн хөрөнгөөр "Дэд бүтцийн хөгжил-Сонгинохайрхан дүүрэг" болон "Дэд бүтцийн хөгжил БЗД, Дархан, Сэлэнгэ" төслийн 2019-2022 онд хэрэгжүүлсэн бөгөөд Хөрөнгийн өмчлөлийг шийдвэрлүүлэхээр 2023 оны 11 дүгээр сарын 22ны өдрийн 3/4224 болон 12 дугаар сарын 04-ний өдрийн 3/4399, тоот бичгээр тус тус ТӨБЗГ-т хүргүүлсэн.<br><br>Гэвч Сангийн яамнаас эцсийн гүйлгээний шилжүүлгийг 2023 онд хийсэнтэй холбогдуулан ханшийн зөрүү үүссэн. Үүнтэй холбогдуулан хөрөнгийн өмчлөлийг шийдвэрлүүлэх албан хүсэлтийг дахин 2024 оны 5 дугаар сарын 27-ны өдрийн 3/1696 болон 3/1697 тоотоор ТӨБЗГ-т тус тус хүргүүлсэн. Мөн ТӨБЗГ-аас тодруулга ирүүлсэнтэй холбогдуулан хариу бичгийг 06 дугаар сарын 24-ний өдрийн 03/2056 тоот албан бичгээр ТӨБЗГ-т хүргүүлсэн. | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 3 | **Арга хэмжээ 2.3:** Барилга, хот байгуулалтын салбарт гадаадын зээл, тусламжаар хэрэгжиж буй төслүүдийн гэрээ хэлэлцээрийн дагуу импортоор оруулж ирэх бараа материал, тоног төхөөрөмжийг гаалийн болон НӨАТ чөлөөлөлтөд хяналт тавьж, шийдвэрлүүлэх, дотоодын зах зээлээс худалдан авах бараа, ажил үйлчилгээг нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх жагсаалтыг батлуулах асуудлыг ТУХ-ны хурлаар хэлэлцүүлэх. | **ШҮ1:**Төслийн шинэчлэн батлуулсан импортын жагсаалт;<br><br>**ШҮ2:**Импортын бараа материалын хэрэгжилтийн хувь;<br><br>**ШҮ3:**ТУХ-ны хурлын тоо;<br><br>**ШҮ3:**СЯ- хүргүүлсэн санал. | 2023 онд шинэчлэн батлуулсан импортын жагсаалт -4;<br><br>Хэрэгжилтийн хувь 85%;<br><br>ТУХ-ны хурлын тоо-3;<br><br>Дотоодын зах зээлээс худалдан авах бараа, ажил, үйлчилгээг нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх санал-3. | 2024 онд шинэчлэн батлуулсан импортын жагсаалт -5;<br><br>2024 оны Импортын бараа материалын хэрэгжилтийн хувь-80-90%<br><br>ТУХ-ны хурлын тоо-3;<br><br>Дотоодын зах зээлээс худалдан авах бараа, ажил, үйлчилгээг нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх санал-3. | Сангийн сайдын 2023 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн А/30 дугаар тушаалаар баталсан журмын дагуу 2024 онд гадаад зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж буй 6 төслийн хүрээнд нийт 655,624.39 сая төгрөгийн импортоор оруулж ирэх бараа материалын жагсаалтыг тус яамны Төрийн нарийн бичгийн даргаар баталгаажуулсан. Үүнд:<br>1. БНХАУ-ын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй "Улаанбаатар хотын төв цэвэрлэх байгууламжийг шинээр барих" төсөл-374.35 тэрбум төгрөг;<br>2. БНХАУ-ын буцалтгүй тусламжаар хэрэгжүүлж буй "Ногоон нуур 1008 айлын орон сууц барих" төсөл-34.3 тэрбум төгрөг;<br>3. БНПУ-ын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй "Аймгуудын бохир ус цэвэрлэх байгууламжийг өргөтгөн шинэчлэх, шинээр барих төсөл"- 32.01 тэрбум төгрөг;<br>4. Бүгд Найрамдах Австри Улсын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр хэрэгжиж буй "Дархан хотын цэвэр усны шугам сүлжээг өргөтгөх, шинэчлэх, ухаалаг тоолуур нэвтрүүлэх" төсөл-8.4 тэрбум төгрөг;<br>5. БНСУ-ын зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй "Солонго 1 орон сууцны хороолол барих төсөл"- 113.24 тэрбум төгрөг;<br>6. БНСУ-ын зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй "Солонго 2 орон сууцны хороолол барих төсөл"-93.23 тэрбум төгрөг.<br>Дээрх төслүүдээс 2024 оны жилийн эцсийн байдлаар нийт 310,166.42 сая төгрөгийн импортын бараа материалыг гааль, НӨАТ-ын чөлөөлүүлэх хүсэлтийг тус яаманд ирүүлж шийдвэрлүүлсэн. Хугацаа хоцролт, буцаалт үүсээгүй байна<br><br>Дээрх төслүүдийн дотоодын зах зээлээс худалдан авах бараа, ажил үйлчилгээг нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх жагсаалтыг батлуулж, Сангийн яаманд хүргүүлж, холбогдох татварын код олгуулсан. | 1-12 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 4 | **Арга хэмжээ 2.4:** Салбарын хэмжээнд гадаад зээл, тусламжаар хэрэгжиж буй төслүүдийн Төслийн удирдах хорооны хурлыг зохион байгуулах, хэрэгжилтийг хангуулах. | **ШҮ1:** ТУХ-ны хурлын тоо /2-оос доошгүй удаа-Төсөл тус бүр/;<br><br>**ШҮ2:**Төслийн удирдах хорооны шийдвэр-тогтоол, зөвлөмж;<br><br>**ШҮ3:**ТУХ-аас гарсан шийдвэрийн биелэлт /хагас, бүтэн жил/. | Гадаад зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй төслийн тоо 11;<br><br>Төслийн удирдах хорооны хурлыг 24 удаа зохион байгуулсан.<br><br>ТУХ-оос нийт 42 үүрэг даалгавар өгөгдсөн ба шийдвэрийн биелэлт-95%. | Гадаад зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй төслүүдийн Төслийн удирдах хорооны хурлын тоо 12 удаа; ТУХ-ны шийдвэр-зөвлөмж, тогтоол; ТУХ-ны шийдвэрийн биелэлт 60-70 хувь. | 2024 онд гадаад зээл, тусламжийн хөрөнгөөр 7 төсөл хэрэгжүүлж байгаа ба Төслийн Удирдах хорооны бүрэлдэхүүнийг Барилга, хот байгуулалтын сайдын 2024 оны 23, 24, 25, 26, 27 дугаар тушаалаар мөн Төслийн захирлуудыг Барилга, хот байгуулалтын сайдын 2024 оны Б/31 дүгээр тушаалаар тус тус шинэчлэн батлуулсан.<br>Барилга, хот байгуулалтын салбарт гадаад зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлж төслүүдээс 7 төслийн, Төслийн удирдах хорооны хурлыг 24 удаа зохион байгуулсан.<br><br>ТУХ-оос 2024 онд 6 тогтоол 44 зөвлөмж төсөл хэрэгжүүлэх нэгжүүдэд гарсан байна. биелэлт 90 хувьтай байна.<br><br>ТУХ-ны шийдвэрийг тухай бүр баталгаажуулан Төсөл хэрэгжүүлэх нэгжид хүргүүлсэн.<br><br>Сангийн сайдын 2021 оны 4 дүгээр тушаалаар баталсан журамд нэмэлт, өөрчлөлт орсонтой холбогдуулан төслийн албан хаагчдын цалинг шинэчлэн тогтооход шаардлагатай 4 төслийн 52 албан хаагчийн холбогдох баримт бичгийг төсөл хэрэгжүүлэх нэгжээс авч хянан СЯ-нд холбогдох баримтын хамт хүргүүлсэн. | 1-12 | 100 |
| | **Зорилт 3:** Төрийн сангийн гүйлгээг гүйцэтгэх, тайлан, баланс гаргах. | | | | | | |
| 5 | **Арга хэмжээ 3.1:**<br><br>Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газраас ирүүлсэн зөвлөмжийн хэрэгжилтийг хангуулах. | **ШҮ1:**Хэрэгжилтийн хувь | | Хэрэгжилтийн хувь 10-30 хувь | Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын Төрийн өмчийн хяналт шалгалтын хэлтэст холбогдох хэрэгжилтийн тайлан мэдэг гаргаж өгч, биеэр очиж тайлбар тодруулгыг өгсөн. | 5-12 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | **Арга хэмжээ 3.2:**<br>Төрийн сангийн гүйлгээг гүйцэтгэх, тайлан, баланс гаргах. | Санхүүгийн тайлан-3;<br>Тооц нийлсэн акт-3 | | | БНАУ-ын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр хэрэгжиж буй “Тайшир-Алтай ус хангамж төсөл”, “Дэд бүтцийн хөгжил-Сонгинохайрхан, Баянзүрх, Дархан, Сэлэнгэ төсөл”-үүдийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг гарган Сангийн яаманд 2024.01.25-ны өдөр хүргүүлж Сангийн яамны санхүүгийн тайланд нэгтгүүлэн ҮАГ-ын шалгалтанд хамруулж холбогдох мэдээ мэдээлэл судалгааг гарган өгсөн. | 1 | 100 |
| | Нэмэлт үүрэг даалгавар /арга хэмжээ/ | | | | | | |
| 1 | Удирдлагаас өгөгдсөн үүрэг даалгаварыг хэрэгжүүлэх | Өгөгдсөн үүрэг даалгаврын хэрэгжилт хангуулсан байна. /90%-с дээш/. | - | Хэрэгжилтийн хувь 90 хувь | Бүгд Найрамдах Польш Улсын зээлийн хөрөнгөөр “Аймгуудын бохир ус цэвэрлэх байгууламжийг өргөтгөн шинэчлэх, шинээр барих төсөл /Баян-Өлгий, Говьсүмбэр, Дорнод, Увс, Завхан/”-ийн хүрээнд 4 аймгийн цэвэрлэх байгууламж барих ажлын гүйцэтгэгч Польш Улсын “Смарт Вэйст Технолоджис” ХХК-тай байгуулсан гэрээний нэмэлт, өөрчлөлт /№2/-ийг баталгаажуулан СЯ-нд хүргүүлсэн.<br>- Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн гишүүнээр томилогдсонтой холбогдуулан 4 удаагийн Салбар зөвлөлийн хуралд оролцсон.<br>- Бүгд Найрамдах Солонгос Улсын зээлийн хөрөнгөөр хэрэгжиж буй “Солонго 1 орон сууцны хороолол барих төсөл /МОН-18/” болон “Солонго 2 орон сууцны хороолол барих төсөл /МОН-19/”-ийн “Барилга угсралтын ажлын захиалагчийн техникийн хяналтын санхүүжилтийн тухай” Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулж, ЗГ-ын гишүүдийн саналыг нэгтгэж, Засгийн газрын ээлжит хуралдаанд оруулж, Засгийн | 1-6 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | газрын 2024 оны 252 дугаар тогтоол гаргуулсан.<br>- Тус яамны Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны А/56 дугаар тушаалаар 2 төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах Үнэлгээний хорооны нарийн бичгийн даргаар ажилласан. Гүйцэтгэгчтэй байгуулах зөвлөмжийг хүргүүлсэн.<br>- БНФУ-ын Засгийн газрын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр хэрэгжсэн “Эрдэнэт хотын 24000м3/хон бохир ус цэвэрлэх байгууламжийн өргөтгөл төслийн ажлыг хүлээлцэх ажлын томилогдсон бөгөөд холбогдох мэдээллийг гаргаж өгсөн.<br>- БНПУ-ын зээлийн хөрөнгөөр “Аймгуудын бохир ус цэвэрлэх байгууламжийг өргөтгөн шинэчлэх, шинээр барих төсөл”-ийн хэрэгжүүлж буй “Дорнод аймгийн цэвэрлэх байгууламжийн өргөтөл, шинэчлэл”-ийн ажлын өртгийг 13,05 сая еврогоор нэмэгдүүлэх Засгийн газрын тогтоолын төслийн саналыг холбогдох баримт материал, танилцуулгыг бэлтгэн Сангийн яаманд 2024 оны 02/698 тоот албан бичгээр хүргүүлсэн.<br>- Хүүхэд хамгааллын ёс зүйн дүрмийг яамны албан хаагчдад танилцуулан нийт 73 албан хаагчдаас холбогдох зөвшөөрлийг баталгаажуулан авч хүний нөөцийн ажилтанд өгсөн.<br>- Тус яамны харьяа төслүүдийн үйл ажиллагаатай танилцах ажлын хуваарийг Төрийн нарийн бичгийн дарга /Ц.Баярбат/-аар батлуулж, уг | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хуваарийн дагуу "Ногоон нуур 1008 айлын орон сууц барих төсөл"-д очиж танилцсан.<br>- Азийн хөгжлийн банкны зээлийн хөрөнгөөр "Дархан хотын бохир усны менежментийг сайжруулах МОН3244/3245 төсөл"-ийг 2016-2024 онд хэрэгжүүлж дуусгасан бөгөөд уг төслийн Зээл хэрэгжүүлэх зөвлөх болох "Fichtner GmbH & Co.KG" компани нь тус яамтай байгуулсан C1/2016 дугаартай гэрээний хүрээнд боловсруулсан төслийн эцсийн тайланг хянаж үзээд тус тайланд дараах мэдээлэл болон үнэлгээг нэмж тусган хүргүүлэх талаар Зээл хэрэгжүүлэх зөвлөхөд цахимаар хүргүүлсэн.<br><br>Барилга, хот байгуулалтын яамны захиалгаар хэрэгжүүлж буй дараах 2 төслийн Төсөл хэрэгжүүлэх нэгжийг байгуулах саналыг Сангийн яаманд хүргүүлэв.<br><br>- БНХАУ-ын Засгийн газрын 700.0 сая юанийн буцалтгүй тусламжийн хөрөнгөөр хэрэгжих "Монгол, Хятадын Төрийн тэргүүн нарын нэрэмжит спортын цогцолбор" төсөл;<br><br>- Солонгосын Экспорт-Импорт банкны хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа "Солонго-1 болон Солонго-2 орлогод нийцсэн орон сууцны хороолол" төсөл.<br>- Төслийн ажилтнуудын хөлсөөр ажиллах гэрээг баталгуужуулахтай холбогдуулан ажилтнуудын нийгмийн даатгалын лавлагааг дахин авч давхар | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | төлөлттэй ажилтнуудын мэдээллийг Хуулийн хэлтсийн даргад өгсөн. | | |

Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээ

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хэрэгжилт | Эхэлсэн, дууссан хугацаа /сараар/ | хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1. | **Арга хэмжээ 1.** Монгол бичгийг бие даан суралцана. | Суралцсан цаг | Анхан шатны мэдлэгтэй | Түвшин тод | Төрийн удирдлагын академийн Монгол бичгийн 40 цагийн сургалтад цахимаар суралцсан анхан шатны үнэмлэх авсан. | 1-12 | 100% |
| 2. | **Арга хэмжээ 2.** Удирдлагын академид Төрийн захиргааны чиглэлээр магистрын дипломын ажлын баримт бичгийг боловруулж, хамгаална | Төрийн захиргааны чиглэлээр магистрын зэрэг горилсон байна. | Төрийн захиргааны чиглэлээр магистрын сургалтад бүрэн хамрагдсан бөгөөд урьдчилсан дизайн хамгаалалтад орсон. | Магистрын сэдвийн хүрээнд судалгаа тооцоо хийх | Дипломын ажлын баримт бичгийн холбогдох судалгаа, шинжилгээг хийсэн. | 5-6 | 90% |
| 3 | Хариуцсан чиглэлийн сургалт, семинарт оролцох | Сургалтад хамрагдах | ХАА-ны А3 хугацаа дууссан. | Сургалтад бүрэн хамрагдаж холбогдох гэрчилгээг авсан байх | АХБ-аас зохион байгуулж буй “Төслийн үнэлгээний семинар”-т хамрагдаж, төслүүдийн эцсийн тайланг бичих аргачилал, сургамж, үнэлэх аргачилалыг судалсан. | 3 | 100 |
| 4 | | | | | ХАА-ны сургалтад хамрагдаж, 2024 оны 04 дүгээр сарын 29-ны өдөр шалгалт өгч, А3 гэрчилгээ авсан. | 4 | 100 |
| 5 | | | | | АТГ-аас зохион байгуулсан “MNS 7023:2023” -Улс, орон нутгийн төсөв болон гадаад зээл тусламжийн хөрөнгөөр санхүүжих бүтээн байгуулалтын ажлын мэдээллийн самбарт тавих шаардлага” сэдэвт хэлэлцүүлэгт 2024 оны 04 дүгээр 26-ны өдөр хамрагдсан. | 4 | 100 |

***ТАЙЛАГНАСАН:***

*ТХХ-ийн шинжээч* *Д.Баярмаа* *2024.12.15*
*(Албан тушаал)* *(Нэр, гарын үсэг)* *(Огноо)*